

**МОНГОЛБАНКНААС АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
2019 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хамрах чиглэл	№	Хийж гүйцэтгэх ажлууд	2019 оны төлөвлөгөөт ажлууд
4.1.3.5 "банк, санхүүгийн байгууллагын санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгож, давуу байдлааа шиглан иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсоох"	1	Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг авах.	<p>- Зээлийн мэдээллийн талаарх олон нийтийн ойлголт, боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зээлийн мэдээллийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах. Энэ ажлын хүрээнд Олон улсын санхүүгийн корпорацитай хамтарч ажиллах;</p> <p>- Зээлийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд мэдээллийн технологийн дэвшил бүхий програм хангамжийг нэвтрүүлэх;</p> <p>- Монголбанкнаас гүйцэтгэж буй “Банкны зээлийн төлөв”-ийн түүвэр судалгааны дагуу банкуудын зээлийн нөхцөл, эрэлт хэрхэн өөрчлөгдөж байгааг тандаж, Монголбанкнаас хэрэгжүүлж буй зээлийн бодлогод тусгахаар 2019 онд үргэлжлүүлэн гүйцэтгэх;</p> <p>- 2018 онд Монголбанкнаас “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023 ”-ийн баримт бичгийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан ба уг стратеги, төлөвлөгөөний хүрээнд 2019 онд санхүүгийн зах зах зээлийг хөгжүүлэх, зээлийн хүүг бууруулж, зээлийн нөхцлийг хөнгөвчлөх чиглэлээр суурь эдийн засгийн судалгаануудыг Монголбанкны дотоод ажлын төлөвлөгөөнд тусган, гүйцэтгэхээр ажиллах.</p>
	2	Банк зээл олгохдоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох.	-Банкны хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тухай бүр арилгуулах арга хэмжээг цаг алдалгүй авах.
	3	Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх.	<p>-“Зээл олгох, зээлийн эрсдэлийг үнэлэх журам”-ын төслийг боловсруулснаар банкны зээлийн бодлогыг тодорхойлох, банкнаас иргэн хуулийн этгээдэд зээл олгоход тавих шаардлага, баримтлах ерөнхий зарчим, үйл явцтай холбоотой харилцааг зохицуулах;</p> <p>-“Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ын төслийг боловсруулснаар банкны барьцаа хөрөнгийг бодит зах зээлийн үнэлгээгээр үнэлснээр зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангах.</p>
	4	Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах.	-“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нэмэлт өөрчлөлт орууланбанкны зээлийн ангилал хийх, эрсдэлийн сан байгуулах шаардлагыг сайжруулснаар шударга өрсөлдөөнийг дэмжиж, Банкны тухай хуулийн 35.5, 35.6 дугаар заалтуудын хэрэгжилтийг хангуулах.
	5	Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах.	-Банк хувьцаат компанихэлбэрээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр СЗХ-той хамтран ажиллах.